



ХЭНТИЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 71

Чингис хот

Сонгон шалгаруулалтын комисс
байгуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 4.1, 4.2, 2013 оны 128 дугаартай тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.8, 2.3, 2.3.2, заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Баян-Адарга, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Хэрлэн, Батширээт, Баянмөнх, Хэрлэнбаян-Улаан тосгоны Соёлын төвийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалттай холбоотой иргэдээс гарсан санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Лхагвахатан	-Салбар зөвлөлийн гишүүн, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ч.Болормаа	-Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн Хүний нөөцийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Г.Болд	-Салбар зөвлөлийн гишүүн, Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
	Ц.Мөнгөнзул	-Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Баатарцогт	-Боловсрол, соёл, урлагийн газрын соёлын асуудал эрхэлсэн мэргэжилтэн

2. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгон зохион байгуулж, сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийн онооны жагсаалт, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлангийн хамт Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг комиссын дарга /Г.Лхагвахатан /-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР

